



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.03.01

№	Зөвлөмжийн заалт	Хэрэгжүүлэх заалт	Хамрах хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Биелэлт
1	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох	<p>1.1 ТЗУГ-ын “Хууль эрх зүй” сургалтын хөтөлбөрт “Авлигын эсрэг” хуулийн талаарх сургалт зохион байгуулах талаар тусгах</p> <p>1.2 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 2017 онд Авлигатай тэмцэх газарт хянуулсан байдалд үнэлгээ хийх</p> <p>1.3 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулсны дараа томилдог байх</p>	Жилдээ	ТЗУГ, харьяа байгууллагын удирдлага	
2	Албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд	<p>2.1 Албан тушаалд томилогдсон албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргаж хэвшүүлэх, хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, худал мэдүүлсэн албан хаагчид хариуцлага хүлээлгэх</p> <p>2.2 Салбарын хэмжээнд албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр АТГ-тай хамтран сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах</p>	Жилдээ	ТЗУГ, харьяа байгууллагын удирдлага	

	хариуцлага тооцох, хяналтыг сайжруулах				
3	Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлэх, энэ талаарх мэдээллийг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болгох	3.1 Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд бичгээр тайлбар гаргаж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн эсэхэд үнэлгээ хийх 3.2 Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргасан талаарх мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны вэб сайтад байршуулах	Жилдээ	ХШҮДАГ, харьяа байгууллагын удирдлага	
4	Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог, төрийн захиргааны албан тушаалын орон тоон дээр гэрээ байгуулан ажиллуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгон ажиллах	4.1 Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө мэргэшлийн шалгалт өгсөн, төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэнийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, Зам, тээврийн хөгжлийн яамны вэб сайтад байршуулж хэвших 4.2 Зам, тээврийн салбарын хэмжээнд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар сургалт зохион байгуулах 4.3 Төрийн жинхэнэ албан хаагчийг шинээр болон дэвшүүлэн томилохдоо “Мерит зарчим”-г удирдлага болгож ажиллах 4.4 Гэрээгээр ажиллаж байсан иргэнийг шалгалтанд хамруулах, тухайн албан хаагч төрийн албаны шалгалтад тэнцсэн тохиолдолд томилох, төрийн албаны шалгалтад тэнцээгүй тохиолдолд ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч ажиллах	Жилдээ	ТЗУГ, харьяа байгууллагын удирдлага	
5	Нийтийн албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөх, түүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох	5.1 Нийтийн албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөх, түүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох 5.2 Салбарын хэмжээнд шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг үндэслэн ажлаас чөлөөлж буй байдалд үнэлгээ хийх	Жилдээ	ТЗУГ, харьяа байгууллагын удирдлага	
6	Засгийн газрын тогтоолоор баталсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл	6.1 Албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, үр дүнг бодитой шударга үнэлж дүгнэж байх	Жилдээ		

	ажиллагааг хэрэгжүүлж, албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг бодитоор үнэлж, хууль журамд нийцүүлэн олгох	6.2 Үр дүнгийн гэрээний биелэлтийг бодитой үнэлж дүгнээгүй нэгжийн дарга нарт хариуцлага тооцох		Бүх газар, хэлтсийн дарга, харьяа байгууллагын удирдлага	
7	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг салбарын хэмжээнд өрнүүлж эрчимжүүлэх	7.1 Салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах 7.2 ЗТХ-ийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Хууль-эрх зүй сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулахдаа Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг байнга сурталчилж ажиллах 7.3 Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар сурталчлах, ил тод хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний талаар судалгаа, үнэлгээ хийх	Жилдээ	Бүх газар, хэлтсийн дарга, харьяа байгууллагын удирдлага	
8	Удирдах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож буй үйлдлийг таслан зогсоох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийтийн албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх	8.1 Удирдах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгох нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж ашиг сонирхлын зөрчилгүйн баталгааг бичгээр гаргуулж хэвших 8.2 Салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ хийх 8.3 Салбарын хэмжээнд “Ёс зүйн хороо”-ны ажлыг сайжруулах	Жилдээ	Бүх газар, хэлтсийн дарга, харьяа байгууллагын удирдлага	
9	Иргэний нисэхийн ерөнхий газрын тэтгэлгээр гадаад улсын их, дээд сургуулиудад оюутан суралцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг бодитоор төлөвлөх, сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод зохион байгуулж, олон нийтийн танилцуулах боломжоор хангах	9.1 Иргэний нисэхийн чиглэлийн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгааг жил бүр хийж, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудлыг шийдвэрлэх 9.2 ИНЕГ-ын удирдах албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож буй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах 9.3 Иргэний нисэхийн чиглэлийн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгааг жил бүр хийж, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудлыг шийдвэрлэж байх	Жилдээ	ХШҮДАГ ИНЕГ-ын удирдлага	

		9.4 ИНЕГ-ын тэтгэлгээр гадаад улсын их дээд сургуулиудад оюутан суралцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлан хэрэгжүүлэх			
10	“Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн гэрээний үүргийн биелэлт, орлого төвлөрүүлэлт, зарцуулалтад тавих хяналтын тогтолцоог сайжруулах, “Монгол Улсын далайн захиргаа” улсын төсөвт үйлдвэрийн газрын статусыг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцүүлэх	10.1. “Далайн захиргаа” улсын төсөвт үйлдвэрийн газрын статус, бүтэц, зохион байгуулалтын ажлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцсэн санал боловсруулах	Жилдээ	ТЗДТБХЗГ Далайн захиргаа	
11	Худалдан авах ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу ил тод, нээлттэй цахим хэлбэрээр зохион байгуулж урьд илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн орлого, түүний зарцуулалт хуваарилалтыг олон нийтэд нээлттэй мэдээлэх	11.1 Худалдан авах ажиллагааг хууль, журам зөрчин зохион байгуулсан, шийдвэрлэсэн албан тушаалтанд хариуцлага тооцож, цаашид худалдан авах ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллах 11.2 Албан хаагчдын хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх 11.3 Худалдан авах ажиллагааны талаарх мэдээ тайланг нээлттэй ил тод байлгаж, Зам, тээврийн хөгжлийн яамны вэб сайтад байршуулах	Жилдээ	Бүх газар, хэлтсийн дарга, харьяа байгууллагын удирдлага	